

УИХ-ЫН СОНГУУЛЬД НЭР ДЭВШҮҮЛЭХ ТУХАЙ ЖУРАМ

Нэгдүгээр бүлэг.

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Журмын зорилт Энэ журмын зорилт нь УИХ-ын сонгуульд Иргэний Зориг Ногоон Намаас нэр дэвшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Журмын эрх зүйн үндэс Журам нь Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намуудын тухай хууль, холбогдох бусад хуулиуд болон Иргэний Зориг Ногоон Намын дүрэм болон эрхийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Нэр дэвшигчийг сонгоход баримтлах үндсэн зарчим

1. Нэр дэвшигчийг сонгоход дараах зарчмыг баримтална.

Үүнд: • Хууль дээдлэх • Ил тод байдлыг хангах • Шударга ёсыг сахих

2. УИХ-д нэр дэвшигч тодруулахдаа улс орны болон ИЗНН-ын нийтлэг эрх ашгийг төлөөлөх чадварыг гол болгоно.

3. Нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна.

4. Эрүүгийн болон авилгалын хэрэгт холбогдоогүй хүн байна.

5. Нэр дэвшүүлэх, баталгаажуулах, бүх шатны хуралд гишүүдийн шударга санал хураалтаар, энгийн олонхиор дэмжигдэж шийдвэр баталгаажина.

6. Санал өгөх Хурлын гишүүдэд нэр дэвшигчдийн талаарх үнэн бодит мэдээлэлийг бүрэн өгч, нэр дэвших ажиллагааны ил тод байдлыг хангана.

7. Шийдвэр гаргалтанд мөнгөн амлалт, санхүүжилтын нөлөөг харгалзах гол хүчин зүйл болгохыг хориглоно.

8. Нэр дэвшигчийн сонгохдоо нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.

9. Нэр дэвшигч нь ИЗНН-тай "Улс төрийн гэрээ"-г албан ёсоор байгуулна.

10. Дээрх шаардлагууд тойрогт нэр дэвших болон жагсаалтаар нэр дэвшихэд адил үйлчилнэ.

Хоёрдугаар бүлэг

4 дүгээр зүйл. УИХ-ын Сонгуульд нэр дэвшүүлэх явц:

1. Нэр дэвшигчид нь Аймаг, Дүүргийн ИЗНН-ын Бага хурлаас нэр дэвшинэ.

2. Нэр дэвшигч ба Орон нутгийн намын байгууллагын хамтран ажиллах эсэх нь тухайн орон нутагтаа нээлттэй.

3. АД-ын Бага Хурлаас хүлээн зөвшөөрөгдсөн нэр дэвшигч нь Үндэсний Хорооны хурлаар хэлэлцэгдэж, шийдвэрлэнэ.

4. Нэр дэвшигчийг сонгоход ИЗНН-ын удирдлагаас Үндэсний хороонд санал оруулж болно.

5. Санал хураалтанд оролцсон Үндэсний Хорооны хурлын гишүүдийн ердийн олонхийн санал авч баталгаажсан нэр дэвшигчийг ИЗНН-аас УИХ-ын сонгуульд албан ёсоор нэр дэвшигч гэж үзнэ.

6. Нэр дэвшигч нь ИЗНН-аас нэр дэвшигчидтэй байгуулах "Улс төрийн гэрээ"-г албан ёсоор хүлээн зөвшөөрч, гарын үсэг зурна.

7. Нэр дэвшигч Сонгуулийн хуулинд заагдсан үүргийг биелүүлэх, дагаж мөрдөх болно.

5 дугаар зүйл. Тойрогт нэр дэвшүүлэхэд баримтлах шалгуур

1. Тойрогт нэр дэвшигч нь дараахь шалгуурыг хангасан байна.

1.1. Хуулинд заагдсан болзолыг хангасан хүн байна.

1.2. Тойрогт нэр дэвшин өрсөлдөхөд шаардагдах санхүүг бие даан хариуцах чадвартай байна.

2. Нэр дэвшигч дараахь зардлыг санхүүжүүлнэ.

Үүнд: 2.1. Сонгуулийн үйл ажиллагааны зардал

2.2. Олон нийтийн мэдээлэл харилцааны зардал

2.3. Хэвлэлийн зардал

2.4. Сурталчилгааны самбарууд

2.5. Сонгуулийн штабын зардал

2.6. Тээврийн зардал

2.7. Түрээсийн байрны зардал

2.8. Сонгуулийн ажилд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, ажиллагсдын хоол

3. Тойрогт нэр дэвшигч нар нь дээрх зардлыг хариуцан санхүүжүүлэх баталгаа болгож эскроу данс нээсэн байна.

4. Тойрогтоо танигдсан байдал

4.1. Тойргоо хэр сайн мэдэх

4.2. Тойргоосоо урьд өмнө нэр дэвшиж байсан эсэх

4.3. Тойргоо хийж гүйцэтгэсэн ажил

6 дугаар зүйл. Намын жагсаалтад нэр дэвшүүлэхэд баримтлах шалгуур

1. Намын жагсаалтаар жагсаахдаа нэр дэвшигчдийг 7,7-р нь 4 бүлэг болгон хувааж, бүлэг бүр дотор нь эрэмбэ тогтоон жагсаана.
2. Нэр дэвшигчдийг эрэмбэлэх тохиолдолд гурван нэр дэвшигч тутамд нэгээс доошгүй эмэгтэй нэр дэвшигч байна.
3. Өмнө нь аль нэг тойрогт ИЗНН-аас нэр дэвшиж байсан эсэх. Үүнд ИЗНН-д нэгдсэн бусад намаас нэр дэвшиж байсан тохиолдолд мөн адил хамаарна.
4. Жагсаалтыг сонгуулийн Тойрогт нэр дэвшиж намын "Үнэт өв"-ийг бүрдүүлж, тойргоосоо ялсан байдал
5. Урьд өмнөх сонгуульд авсан саналын тоо
6. Үндэсний хорооны гишүүдээс өгсөн үнэлгээ